

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/224/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МУЗЕЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjarqalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГ

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл.....
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 25 № 01/151
танай _____-ны № _____-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 5 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 98,2 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,276,882.01	56,663,159.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,027,779.51	23,706,669.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,027,779.51	23,706,669.55
3121	Төгрөг	6,027,779.51	23,706,669.55
31211	Төрийн сангийн харилцах	6,027,779.51	23,706,669.55
35	БАРАА МАТЕРИАЛ	34,249,102.50	32,956,490.30
354	Хангамжийн материал	34,249,102.50	32,956,490.30
35410	Бичиг хэргийн материал	1,576,080.00	955,850.00
35420	Аж ахуйн материал	19,566,500.00	19,687,830.00
35440	Түлш, шатах тослох материал	5,324.00	305,011.80
35470	Бусад хангамжийн материал	13,101,198.50	12,007,798.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,048,485,129.46	1,099,636,259.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,048,485,129.46	1,099,636,259.59
392	Биет хөрөнгө	996,711,129.46	1,048,246,259.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	626,932,823.00	626,932,823.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(545,379,561.56)	(557,228,345.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,000,000.00	27,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,000,000.00)	(27,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,195,784.15	108,888,712.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,275,392.86)	(34,266,892.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,476,540.00	39,019,040.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,598,043.31)	(29,406,757.11)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	877,112,880.00	890,805,280.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,229,750.00	5,229,750.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(983,649.96)	(1,727,351.76)
393	Биет бус хөрөнгө	51,774,000.00	51,390,000.00
39301	Програм хангамж	1,970,000.00	1,920,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(146,000.00)	(480,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	49,950,000.00	49,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,088,762,011.47	1,156,299,419.44
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,088,762,011.47	1,156,299,419.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,088,762,011.47	1,156,299,419.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	402,382,470.00	402,382,470.00
51101	Өмч: - төрийн	402,382,470.00	402,382,470.00
512	Хуримтлагдсан үр дүн	(187,198,609.37)	(119,661,201.40)
51210	Өмнөх үеийн үр дүн	(147,583,206.79)	(187,198,609.37)
51220	Тайлант үеийн үр дүн	(39,615,402.58)	67,537,407.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,578,150.84	873,578,150.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,088,762,011.47	1,156,299,419.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	321,301,442.00	560,666,728.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,748,600.00	75,182,852.91
120	Нийтлэг татварын бус орлого	18,748,600.00	75,182,852.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,748,600.00	75,182,852.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,078,000.00	10,978,240.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	989,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,580,600.00	63,215,612.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	302,552,842.00	485,483,875.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	230,987,500.00	393,354,172.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	230,987,500.00	393,354,172.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	33,549,852.56
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,991,830.00
131106	Төсвийн урамшуулал	-	30,558,022.56
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,565,342.00	58,579,851.37
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,222,300.00	64,334,600.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	11,343,042.00	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-	(5,754,748.63)
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	360,916,844.58	493,129,320.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	360,916,844.58	493,129,320.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	352,656,742.68	427,933,694.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,514,009.06	276,148,699.16
210101	Үндсэн цалин	148,056,687.22	188,828,037.37
210102	Нэмэгдэл	36,440,627.54	51,021,699.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,960,500.00	14,788,500.00
210104	Урамшуулал	4,056,194.30	21,510,462.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,227,869.53	34,227,869.36
210201	Тэтгэврийн даатгал	17,663,347.40	24,408,460.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,924,080.44	2,626,458.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,539,264.39	2,087,966.74
210204	Ажилгүйдлийн даатгал	372,834.30	463,907.61
210205	Эрүүл мэндийн даатгал	3,728,343.00	4,641,076.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,931,912.00	51,525,871.37
210301	Гэрэл, цахилгаан	4,415,807.00	5,845,112.53
210302	Түлш, халаалт	37,129,510.00	44,516,958.84
210303	Цэвэр, бохир ус	386,595.00	1,163,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,675,376.00	23,820,222.20
210401	Бичиг хэрэг	1,492,500.00	2,388,560.00
210402	Тээвэр, шатахуун	1,340,176.00	370,312.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	666,050.00	893,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	176,650.00	17,144,610.00
210408	Бараа материал акталсны зардал	-	3,023,540.00
2105	Нормативт зардал	487,900.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	487,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,805,890.00	120,000.00
210604	Урсгал засвар	7,805,890.00	120,000.00
2107	Томиллолт, зочны зардал	812,000.00	704,000.00
210702	Дотоод албан томиллолт	812,000.00	704,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,073,200.00	4,692,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,073,200.00	4,512,850.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,128,586.09	36,694,182.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,292,000.00	1,843,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,836,586.09	34,850,782.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,260,101.90	65,195,626.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,560,000.00	65,195,626.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,315,400.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	31,082,466.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,560,000.00	9,797,760.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,700,101.90	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,700,101.90	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(39,615,402.58)	67,537,407.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(39,615,402.58)	67,537,407.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	318,720,842.00	497,451,115.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,168,000.00	11,967,240.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,168,000.00	11,967,240.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,168,000.00	11,967,240.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,078,000.00	10,978,240.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	989,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	302,552,842.00	485,483,875.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	230,987,500.00	393,354,172.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	230,987,500.00	393,354,172.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	33,549,852.56
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,991,830.00
131106	Төсвийн урамшуулал	-	30,558,022.56
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,565,342.00	58,579,851.37
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,222,300.00	64,334,600.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	11,343,042.00	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-	(5,754,748.63)
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	303,837,662.49	467,893,225.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,837,662.49	467,893,225.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,577,560.59	402,697,599.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,514,009.06	276,148,699.16
210101	Үндсэн цалин	148,056,687.22	188,828,037.37
210102	Нэмэгдэл	36,440,627.54	51,021,699.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,960,500.00	14,788,500.00
210104	Урамшуулал	4,056,194.30	21,510,462.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,227,869.53	34,227,869.36

210201	Тэтгэврийн даатгал	17,663,347.40	24,408,460.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,924,080.44	2,626,458.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,539,264.39	2,087,966.74
210204	Ажилгүйдлийн даатгал	372,834.30	463,907.61
210205	Эрүүл мэндийн даатгал	3,728,343.00	4,641,076.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,931,912.00	51,525,871.37
210301	Гэрэл, цахилгаан	4,415,807.00	5,845,112.53
210302	Түлш, халаалт	37,129,510.00	44,516,958.84
210303	Цэвэр, бохир ус	386,595.00	1,163,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,641,050.00	1,975,900.00
210401	Бичиг хэрэг	478,500.00	583,100.00
210402	Тээвэр, шатахуун	496,500.00	480,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	666,050.00	893,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	19,600.00
2105	Нормативт зардал	620,900.00	608,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	620,900.00	608,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,944,150.00	7,053,980.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,025,450.00	-
210604	Урсгал засвар	8,918,700.00	7,053,980.00
2107	Томилолт, зочны зардал	812,000.00	704,000.00
210702	Дотоод албан томилолт	812,000.00	704,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,449,670.00	19,509,230.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,449,670.00	19,329,230.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,436,000.00	10,943,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,436,000.00	10,943,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,260,101.90	65,195,626.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,560,000.00	65,195,626.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,315,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	31,082,466.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,560,000.00	9,797,760.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,700,101.90	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,700,101.90	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,883,179.51	29,557,890.04
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,855,400.00	11,879,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,855,400.00	11,879,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,855,400.00	11,879,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,855,400.00	11,879,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,855,400.00)	(11,879,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,027,779.51	17,678,890.04
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,027,779.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	23,706,669.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-147,583,206.79	1,128,377,414.05
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-147,583,206.79	1,128,377,414.05
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-39,615,402.58	-39,615,402.58
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-187,198,609.37	1,088,762,011.47
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-187,198,609.37	1,088,762,011.47
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-187,198,609.37	1,088,762,011.47
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	67,537,407.97	67,537,407.97
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-119,661,201.40	1,156,299,419.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	509,031,000.0	479,772,225.9	29,258,774.1	94.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,031,000.0	479,772,225.9	29,258,774.1	94.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439,068,300.0	414,576,599.9	24,491,700.1	94.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,923,100.0	276,148,699.2	10,774,400.8	96.2
210101	Үндсэн цалин	178,770,900.0	188,828,037.4	(10,057,137.4)	106.0
210102	Нэмэгдэл	62,930,100.0	51,021,699.7	11,908,400.3	81.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,292,000.0	14,788,500.0	2,503,500.0	85.5
210104	Урамшуулал	27,930,100.0	21,510,462.1	6,419,637.9	77.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,865,300.0	34,227,869.4	1,637,430.6	95.4
210201	Тэтгэврийн даатгал	24,388,400.0	24,408,460.3	(20,060.3)	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,869,200.0	2,626,458.2	242,741.8	91.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,295,400.0	2,087,966.7	207,433.3	91.0
210204	Ажилгүйдлийн даатгал	573,800.0	463,907.6	109,892.4	81.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,738,500.0	4,641,076.5	1,097,423.5	81.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,934,600.0	51,525,871.4	5,408,728.6	90.5
210301	Гэрэл, цахилгаан	6,527,600.0	5,845,112.5	682,487.5	89.5
210302	Түлш, халаалт	45,283,600.0	44,516,958.8	766,641.2	98.3
210303	Цэвэр, бохир ус	5,123,400.0	1,163,800.0	3,959,600.0	23.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,975,900.0	1,975,900.0	-	100.0
210401	Бичиг хэрэг	622,400.0	583,100.0	39,300.0	94.0
210402	Тээвэр, шатахуун	496,500.0	480,000.0	16,500.0	97.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	557,000.0	893,200.0	(336,200.0)	160.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.0	19,600.0	280,400.0	65.3
2105	Нормативт зардал	987,000.0	608,400.0	378,600.0	62.0

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	987,000.0	608,400.0	378,600.0	62.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,373,200.0	18,932,980.0	1,440,220.0	93.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,223,200.0	11,879,000.0	344,200.0	97.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	750,000.0	-	750,000.0	
210604	Урсгал засвар	7,400,000.0	7,053,980.0	346,020.0	95.3
2107	Томилолт, зочны зардал	1,433,800.0	704,000.0	729,800.0	49.1
210702	Дотоод албан томилолт	1,433,800.0	704,000.0	729,800.0	49.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,089,300.0	19,509,230.0	2,580,070.0	88.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,909,300.0	19,329,230.0	2,580,070.0	88.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.0	180,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,486,100.0	10,943,650.0	1,542,450.0	88.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,486,100.0	10,943,650.0	1,542,450.0	88.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,962,700.0	65,195,626.0	4,767,074.0	93.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,962,700.0	65,195,626.0	4,767,074.0	93.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.0	(1,000,000.0)	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,315,400.0	23,315,400.0	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,681,300.0	31,082,466.0	4,598,834.0	87.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,966,000.0	9,797,760.0	1,168,240.0	89.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	494,128,600.0	457,688,772.0	36,439,828.0	93.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	494,128,600.0	457,688,772.0	36,439,828.0	93.0
122005	Орон нутгийн төсвөөс	494,128,600.0	457,688,772.0	36,439,828.0	93.0
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,027,779.5	(6,027,779.5)	
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	23,706,669.6	(23,706,669.6)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Музейн үйл ажиллагааны чиглэл зорилго нь түүх соёлын дурсгалт зүйлийг хадгалж, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Соёл урлагийн яамны харьяа байгууллага юм. Төв аймгийн Музей нь 2023 оныг Соёлын сэргэлтийг дэмжих жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 6 арга хэмжээтэйгээр боловсруулан 95,5 хувиар биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Музей нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 онд 11 сард тус байгууллага нь Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтаар 92,0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Музейн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн тус* байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Музейн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67,537.4 мянган төгрөгөөр буюу 6,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,027.8	23,706.7	17,678.9
Авлага	0	0	
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	34,249.1	32,956.4	1,292.7
Үндсэн хөрөнгө	1,048,485.1	1,099,636.3	51,151.2
Нийт хөрөнгө	1,088,762.0	1,156,299.4	67,537.4
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0	0	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,088,762.0	1,156,299.4	67,537.4

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө данс 17,678.9 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн, нэмэгдэл цалин хэмнэснээс шалтгаалан мөнгө данс өссөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,292.7 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвийн хөрөнгөөр 22,703.8 мянган төгрөгийн бичиг хэрэг аж ахуйн бараа материал худалдан авсан, өөрийн үйл ажиллагаанд 20,972.9 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 51,151.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2023 онд 12,818.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9,967.4 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйлс нийт 22,786.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. Хандиваар 6,524.8 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйл, тоног төхөөрөмж орлогодож авсан байна. Нийт 86,001.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 429,793.3 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээс 64,334.6 мянган төгрөг, нийт зарлагыг 444,696.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг нийт улсын төсвөөс 444,696,4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 64,334,6 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 429,793.3 мянган төгрөгийн санхүүжилт, Орон нутгаас 64,334.6 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого 11,967.2 мянган төгрөг, дээд шатнаас 2,991.8 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 421,192.4 мянган төгрөг буюу 94% хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын цалин болон нэмэгдлийг 10,739.0 мянган төгрөгөөр, нормативт зардал, эд хогшил урсгал засварын зардал зэргийг 12,765.0 мянган төгрөгөөр нийт 23,504.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Соёл урлаг, Үндсэн үйл ажиллагааны зардал/80801/	325,273.4	311,052.5	14,220.9	96,0
2	Соёл урлаг, Эрдэм шинжилгээний зардал/80215/	5,000.0	4,929.1	70.9	98,5
3	Соёл урлаг, Тэтгэмж, урамшуулал/80802/	68,962.7	64,195.6	4,767.1	93,1
4	Соёл урлаг, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал/80111/	64,334.6	64,334.6	0	100
5	Соёл урлаг, Үр дүнд суурилсан урамшуулал/81855/	30,557.9	30,142.2	415.7	99,0
6	Соёл урлаг, Өөрийн орлого/83603/	14,959.0	10,872.8	4,086.2	73,0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Музей нь 2023 онд нэмэлт төсвийн санхүүжилт байхгүй

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	80801	2023-12-31	Үндсэн үйл ажиллагааны	95%	325,273.4	311,052.5
2	80215	2023-12-31	Эрдэм шинжилгээний	98%	5,000.0	4,929.1
3	80802	2023-12-31	Тэтгэмж, урамшуулал	93%	68,962.7	64,195.6
4	81855	2023-12-31	Үр дүнд суурилсан	98%	30,557.9	30,142.2
5	83603	2023-12-31	Үйл ажиллагааны орлого	72%	14,959.0	10,872.8
6	80111	2023-12-31	Тогтмол зардал	100%	64,334.6	64,334.6

Хэрэгжилт огт хангагдаагүй төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Музей нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 44,784.4 мянган төгрөгийн цахилгаан дулаан, цэвэр бохир усны үйлчилгээг гэрээ шууд гэрээ байгуулах аргаар, 1,667.1 мянган төгрөгийн урсгал засвар, 2,405.9 мянган төгрөгийн бичиг хэрэг болон аж ахуйн бараа материалыг шууд худалдан авалтаар нийт 49,414.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Төв аймгийн Музей нь худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу, худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийн хөтлөлт болон хөрөнгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Музейн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 сарын 23 -ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Музейн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 295,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 5,900.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,720.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Музей нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг, авлага үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

Төв аймгийн Музей нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна. Цалин хөлс нэмэгдэл урамшуулал болон нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 12,411.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон норматив зардлаас 5,787.3 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Төв аймгийн Музей нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 156 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж үзлээ

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Музейн 2023 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	90.0	1	90.0	100
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	1	90.0	1	90.0	100.0

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийн биелэлт 100 хувь

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 596.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад шатахууны зарцуулалтыг батлагдсан орц нормоор тооцоогүй 596.0 мянган төгрөгийн алдаа байсныг зохих журмын дагуу нөхөж тооцуулав.

Үүнд: Авто тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтыг тооцоходоо батлагдсан норм баримтлаагүйн улмаас 596.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан нормыг мөрдөөгүй гэсэн заалт болон “Тохиолдсон байх”, “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т Нягтлан бодох бүртгэлийн алдааг гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авто машины шатахууны зарцуулалтын нормыг батлагдсан нормын дагуу бодож хэвших	1	596.0					1	596.0				
Дүн	1	596.0					1	596.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны 159 мэдээлэл байршуулахаас 156-г байршуулж 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1	10,000.0						1	10,000.0
								1	10,000.0
Дүн	1	10,000.0							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn